



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эрүүл мэндийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 19 нэрийн, нийт 39,546,927.98 (гучин есөн сая таван зуун дөчин зургаан мянга есөн зуун хорин долоон төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэрт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө акталж данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 07 дүгээр сарын 25-ны/ний өдрийн
37 дугаар тогтоолын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТЛАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн балансын үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Зөөврийн компьютер	12/28/2017	1	1,676,200.00	1,676,200.00
2	Зөөврийн компьютер /lenovo	12/25/2014	2	2,202,000.00	4,404,000.00
3	Утастай микрофон суурийн хамт	1/1/2008	16	147,929.00	2,366,864.00
4	Дижитал зургийн аппарат Nikon	12/25/2014	1	1,149,900.00	1,149,900.00
5	IP багц камер - 2174	12/26/2012	1	2,414,896.00	2,414,896.00
6	Мемори карт уншигч	11/27/2015	1	115,200.00	115,200.00
7	Мөрний тогтоогч	11/27/2015	1	1,152,000.00	1,152,000.00
8	Мемори карт камер	11/27/2015	2	950,000.00	1,900,000.00
9	Таазны гэрэл	11/27/2015	4	200,000.00	800,000.00
10	Микрофон утасгүй	11/27/2015	1	259,200.00	259,200.00
11	Хувилагч А3 өнгөт олон үйлдэлт	11/27/2015	1	3,400,000.00	3,400,000.00
12	Принтер Canon PIXMA	8/24/2018	2	437,500.00	875,000.00
13	Ipad mini-3	12/31/2015	1	1,400,000.00	1,400,000.00
14	Мөнгө тоологч	12/26/2012	1	280,000.00	280,000.00
15	Принтер epson	3/9/2018	2	730,000.00	1,460,000.00
16	Факс, сканнер канон	12/27/2010	1	1,050,000.00	1,050,000.00
17	Зураасан код хэвлэгч	12/31/2016	1	808,412.53	808,412.53
18	Принтер	12/31/2016	1	880,524.45	880,524.45
19	Тог баригч /2000G, 6kVA/	12/31/2016	2	6,577,365.50	13,154,731.00
НИЙТ ДҮН			42	25,831,127.48	39,546,927.98
				(хорин таван сая найман зуун гучин нэгэн мянга нэг зуун хорин долоон төгрөг дөчин найман мөнгө)	(гучин есөн сая таван зуун дөчин зургаан мянга есөн зуун хорин долоон төгрөг ерэн найман мөнгө)